



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2024/69/НА-СТА-ТШЗ

Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий
Цахим хаяг:	<a href="mailto:gan-ulziit@audit.gov.mn">gan-ulziit@audit.gov.mn</a>
Цахим хуудас:	Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
<a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Цахим хаяг: <a href="mailto:oyuntulkhuur.u@audit.gov.mn">oyuntulkhuur.u@audit.gov.mn</a>
Дорноговь аймаг	Аудитор: Э.Эрдэнэсүвд
2024 он	Цахим хаяг: <a href="mailto:erdenesuvde@audit.gov.mn">erdenesuvde@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	1
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	2
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	<b>Error! Bookmark not defined.</b>
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	9
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	12

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ДОРНОГОВЬ АЙМАГ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гуламж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

2024-02-23 № 1-6/66

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

УЛААНБАДРАХ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Б.ОДЦЭЦЭГ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбадрах сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Улаанбадрах сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 1,226.7 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 20 дугаар зүйлийн 20.2.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3, 20 дугаар зүйлийн 20.2.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”, 2015 оны 7 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Зардлын зориулалт, арга хэмжээний ангилал, Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.4, 19 дүгээр зүйлийн 19.1.3-т заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд иргэдийн Төлөөлөгчдийн 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 13/04 дүгээр тогтоолоор 2023 оны төсвийг 34.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Нэмэгдүүлсэн төсвийг эдийн засгийн ангиллаар задалж үзвэл цалин хөлсний зардлыг 21.3 сая төгрөгөөр, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 2.7 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 0.7 урсгал засварын зардлыг 2.0 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 4.7 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 2.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

010070239

### **Аудитын гол асуудал**

Тайлант онд Улаанбадрах сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын 2023 оны 12 дугаар сарын 11-ны дөрийн А/09 дүгээр тушаалаар 3 албан хаагчид түлээ нүүрсний хөнгөлөлт 600.0 мянган төгрөгийг олгохдоо 62.1 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй, орлогыг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд тайлагнаагүй, ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 7-ны өдрийн 13/04 дүгээр тогтоолоор батлагдсан төсөвт зохицуулалт хийхдээ орон нутгийн нөөц хөрөнгө гэсэн зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр баталж, төсөвт тусгагдаагүй хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэн 4,998.8 мянган төгрөгийг зарцуулж залруулаагүй зөрчлийн нийт дүн 5,660.9 мянган төгрөг нь тогтоосон материаллаг байдлын түвшин 1,226.7 мянган төгрөгөөс их байгаа нь өөрчлөлттэй дүгнэлт өгөх үндэслэл бүхий байна.

### **Бусад асуудлын хэсэг**

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>6,561,063.00</u></b>	<b><u>7,195,715.00</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	1,669,250.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	1,669,250.00
<b>3122</b>	<b>Гадаад валют</b>	-	1,669,250.00
31221	Төрийн сангийн харилцах	-	1,669,250.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,440,000.00	408,852.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	408,852.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,440,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	1,440,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	5,121,063.00	5,117,613.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	5,121,063.00	5,117,613.00
35410	Бичиг хэргийн материал	890,900.00	628,000.00
35420	Аж ахуйн материал	900,163.00	2,947,163.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,000,000.00	77,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,330,000.00	1,465,450.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>23,557,170.56</u></b>	<b><u>15,416,365.03</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	23,557,170.56	15,416,365.03
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	23,557,170.56	15,416,365.03
39203	Авто-тээврийн хэрэгсэл	68,000,000.00	68,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(52,444,444.08)	(66,044,444.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	6,623,000.00	9,803,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,400,816.47)	(3,881,699.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,072,001.43	9,072,001.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	(292,570.32)	(1,532,492.62)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>30,118,233.56</u></b>	<b><u>22,612,080.03</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>6,300.00</u></b>	<b><u>144,000.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	6,300.00	144,000.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	6,300.00	144,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	6,300.00	144,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>30,111,933.56</u></b>	<b><u>22,468,080.03</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	30,111,933.56	22,468,080.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,438,072.56	3,438,072.56
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	26,429,200.75	18,785,347.22
51210	Өмнөх үеийн үр дүн	26,429,200.75	26,429,200.75
51220	Тайлант үеийн үр дүн	-	(7,643,853.53)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	244,660.25	244,660.25
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>30,118,233.56</u></b>	<b><u>22,612,080.03</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>70,439,418.09</b>	<b>122,490,687.89</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>1,669,250.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	1,669,250.00
1200047	Шилжиж ирсэн хөрөнгө	-	1,669,250.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>70,439,418.09</b>	<b>120,821,437.89</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2,000,000.00	300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	300,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	68,439,418.09	120,521,437.89
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	68,439,418.09	120,521,437.89
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>78,424,776.85</b>	<b>130,134,541.42</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>78,424,776.85</b>	<b>130,134,541.42</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	77,824,776.85	129,534,541.42
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	41,527,382.00	81,803,699.60
210101	Үндсэн цалин	32,066,598.00	43,521,456.31
210102	Нэмэгдэл	5,669,371.00	27,225,622.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,911,545.39
210104	Урамшуулал	3,791,413.00	8,145,075.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,425,632.47	10,962,306.29
210201	Тэтгэврийн даатгал	3,742,747.75	8,022,135.21
210202	Тэтгэмжийн даатгал	430,357.82	736,099.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	337,566.22	685,159.61
210204	Ажилгүйдлийн даатгал	79,132.80	158,399.66
210205	Эрүүл мэндийн даатгал	835,827.88	1,360,512.54
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,483,400.00	6,743,580.00
210401	Бичиг хэрэг	1,700,600.00	1,772,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,367,730.00	4,468,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	415,070.00	153,080.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	350,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,947,000.00	1,412,000.00
210604	Урсгал засвар	,947,000.00	1,412,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	157,100.00	772,000.00
210702	Дотоод албан томилолт	157,100.00	772,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,874,838.00	7,325,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,578,000.00	7,051,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	207,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	176,344.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,494.00	3,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	14,409,424.38	20,515,105.53
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,996,750.00	4,194,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,412,674.38	16,320,805.53
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	600,000.00	600,000.00

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	600,000.00	600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	600,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(7,985,358.76)</b>	<b>(7,643,853.53)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	164,345.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	164,345.00	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(164,345.00)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(8,149,703.76)</b>	<b>(7,643,853.53)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>70,439,418.09</b>	<b>122,490,687.89</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>1,669,250.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	1,669,250.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	1,669,250.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө		1,669,250.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>70,439,418.09</b>	<b>120,821,437.89</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2,000,000.00	300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	300,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	68,439,418.09	120,521,437.89
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	68,439,418.09	120,521,437.89
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>69,439,418.09</b>	<b>112,641,437.89</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>69,439,418.09</b>	<b>112,641,437.89</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>68,839,418.09</b>	<b>112,041,437.89</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	40,911,382.00	82,378,287.01
210101	Үндсэн цалин	31,450,598.00	44,339,160.31
210102	Нэмэгдэл	5,669,371.00	26,982,506.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,911,545.39
210104	Урамшуулал	3,791,413.00	8,145,075.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	4,991,148.09	10,658,870.88
210201	Тэтгэврийн даатгал	3,464,652.84	7,718,699.80
210202	Тэтгэмжийн даатгал	391,260.39	736,099.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	306,288.28	685,159.61
210204	Ажилгүйдлийн даатгал	71,313.31	158,399.66
210205	Эрүүл мэндийн даатгал	757,633.27	1,360,512.54
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,477,900.00	6,719,130.00
210401	Бичиг хэрэг	1,250,000.00	1,097,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,812,830.00	3,303,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	415,070.00	448,080.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	350,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,520,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,947,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	2,947,000.00	500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	157,100.00	772,000.00
210702	Дотоод албан томилолт	157,100.00	772,000.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	12,918,138.00	7,516,650.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,621,300.00	7,448,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	176,344.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,494.00	3,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,436,750.00	3,496,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,436,750.00	3,496,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>600,000.00</b>	<b>600,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	600,000.00	600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	600,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>1,000,000.00</b>	<b>9,849,250.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,000,000.00</b>	<b>8,180,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,000,000.00</b>	<b>8,180,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	1,000,000.00	8,180,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,000,000.00	8,180,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(1,000,000.00)</b>	<b>(8,180,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	1,669,250.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	1,669,250.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	3,438,072.56	244,660.25	27,746,213.08	31,428,945.89
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>3,438,072.56</b>	<b>244,660.25</b>	<b>27,746,213.08</b>	31,428,945.89
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,317,012.33)	(1,317,012.33)
C08	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,438,072.56</b>	<b>244,660.25</b>	<b>26,429,200.75</b>	30,111,933.56

D01	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>3,438,072.56</b>	<b>244,660.25</b>	<b>26,429,200.75</b>	30,111,933.56
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>3,438,072.56</b>	<b>244,660.25</b>	<b>26,429,200.75</b>	30,111,933.56
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(7,643,853.53)	(7,643,853.53)
D09	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,438,072.56</b>	<b>244,660.25</b>	<b>18,785,347.22</b>	22,468,080.03

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хэтрэлт хэмнэлт	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	122,674,300.00	120,521,437.89	2,152,862.11	98.25
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	122,674,300.00	120,521,437.89	2,152,862.11	98.25
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	122,074,300.00	119,921,437.89	2,152,862.11	98.24
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	83,462,500.00	82,378,287.01	1,084,212.99	98.70
210101	Үндсэн цалин	45,882,000.00	44,339,160.31	1,542,839.69	96.64
210102	Нэмэгдэл	27,190,100.00	26,982,506.31	207,593.69	99.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,600,000.00	2,911,545.39	688,454.61	80.88
210104	Урамшуулал	6,790,400.00	8,145,075.00	(1,354,675.00)	119.95
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	11,351,100.00	10,658,870.88	692,229.12	93.90
210201	Тэтгэврийн даатгал	7,718,700.00	7,718,699.80	0.20	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	736,100.00	736,099.27	0.73	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	898,500.00	685,159.61	213,340.39	76.26
210204	Ажилгүйдлийн даатгал	192,700.00	158,399.66	34,300.34	82.20
210205	Эрүүл мэндийн даатгал	1,805,100.00	1,360,512.54	444,587.46	75.37

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,854,900.00	7,699,130.00	155,770.00	98.02
210401	Бичиг хэрэг	1,100,000.00	1,097,600.00	2,400.00	99.78
210402	Тээвэр, шатахуун	3,304,900.00	3,303,450.00	1,450.00	99.96
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,000.00	448,080.00	151,920.00	74.68
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	350,000.00	350,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.00	2,500,000.00	-	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,700,000.00	7,700,000.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,200,000.00	2,200,000.00	-	100.00
210602	Тавилга	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	-	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	788,800.00	772,000.00	16,800.00	97.87
210702	Дотоод албан томилолт	788,800.00	772,000.00	16,800.00	97.87
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,417,000.00	7,216,650.00	200,350.00	97.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,150,000.00	7,148,800.00	1,200.00	99.98
210803	Даатгалын үйлчилгээ	165,000.00	64,350.00	100,650.00	39.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	102,000.00	3,500.00	98,500.00	3.43
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,500,000.00	3,496,500.00	3,500.00	99.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,500,000.00	3,496,500.00	3,500.00	99.90
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	600,000.00	600,000.00	-	100.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	600,000.00	600,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	600,000.00	-	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	122,674,300.00	120,521,437.89	2,152,862.11	98.25
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	122,674,300.00	120,521,437.89	2,152,862.11	98.25
132001	Орон нутгийн төсвөөс	122,674,300.00	120,521,437.89	2,152,862.11	98.25

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>300,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>300,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	300,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	300,000.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	300,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	300,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	300,000.00

## 2.7 Аудит хийсэн ахмадын сангийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	-	-
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	-	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	-	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	-	-
<b>210801</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	-
<b>1</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	1,669,250.00	1,669,250.0
<b>35</b>	<b>ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	1,669,250.00	1,669,250.0
120004	Төсвийн байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжих	-	1,669,250.00	1,669,250.0
<b>5</b>	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,669,250.00	1,669,250.0

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 20,285.9 мянган төгрөгийн 4 алдаа илэрснээс аудитын явцад бүрэн залруулсан.

1. Нийт 14,239.4 мянган төгрөгийн 12 ажил гүйлгээг эдийн засгийн ангилал зөрүүлж алдаатай илэрхийлсэн байна.

Энэ нь Монгол Улсын Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “Үйл ажиллагааны зардлыг тайлант хугацааны туршид аккруэл суурьт үндэслэн холбогдох зардлын дансуудад хуримтлуулан бүртгэнэ. Аккруэл суурьт бүртгэлийн хувьд ажил гүйлгээ гарсан бөгөөд мөнгөн дүнг нь хэмжиж тодорхойлох боломжтой болсон үед төлбөр хийгдсэн эсэхээс үл хамааран гарсан зардлаас тайлант хугацаанд хамаарах хэсгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Төсвийн зардлыг батлагдсан төсөв, зарцуулалтын эрхийн баталгаа, эрх бүхий байгууллагын шийдвэр, гэрээг үндэслэж гарсан зардлыг анхан шатны баримтыг үндэслэн хүлээн зөвшөөрч бүртгэнэ.” гэж заасныг зөрчсөн байна.

2. Санхүүгийн тайланд 144.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, 408.8 мянган төгрөгийн авлагыг тус тус илэрхийлээгүй,

3. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 1,003.6 мянган төгрөгөөр дутуу, хуримтлагдсан элэгдлийн зардлыг 99.9 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.

4. Тайлант хугацаанд 4,390.0 мянган төгрөгийн бэлэн мөнгөний ажил гүйлгээг кассын орлогоор дамжуулаагүй өглөгийн дансанд тус тус бүртгэсэн байна.

Энэ нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 14.4.3-т “бүх өр төлбөр” Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4 дүгээр зүйлийн 4.9-т “Мөнгөн зарлагад хяналт тавихын тулд бүх зарлагыг чекээр хийдэг. Гэвч байгууллагууд өдөр тутам гардаг бага хэмжээний мөнгөн дүнтэй ажил гүйлгээг хөнгөвчлөх зорилгоор жижиг мөнгөн санг байгуулдаг”, 4.35 дахь хэсгийн “Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ. Тайлангийн үеийн элэгдлийн шимтгэлийг зардал гэж хүлээн зөвшөөрнө” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Аудитаар нийт 5,660.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 5,660.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 4,434.2 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### **5.1. Албан шаардлага**

1. Улаанбадрах сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын 2023 оны 12 дугаар сарын 11-ны дөрийн А/09 дүгээр тушаалаар 3 албан хаагчид түлээ нүүрсний хөнгөлөлт 600.0 мянган төгрөгийг олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл 62.1 мянган төгрөгийг суутгаагүй, орлогыг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд тайлагнаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 “даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, ... сангийн дансанд шилжүүлнэ”, 16.4 “даатгуулагчийн шимтгэл төлөх тооцоог тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогч, ... гүйцэтгэнэ”, 19 дүгээр зүйлийн 19.1.3-т “ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшуулал” гэсэн заалтуудтай, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/182 дугаар тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан илгээх, хүлээн авах, хянах, баталгаажуулах журам”-тай тус тус нийцэхгүй байна.

2. Тайлант онд сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 7-ны өдрийн 13/04 дүгээр тогтоолоор батлагдсан төсөвт зохицуулалт хийхдээ орон нутгийн нөөц хөрөнгө гэсэн зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр баталж, 4,998.8 мянган төгрөгийг зарцуулж, төсөвт тусгагдаагүй, хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 1.1-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад хуулиар олгогдсон бүрэн эрхтэй

зөрчилдөхгүй, урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсны улмаас тухайн төсвийн жилийн дундуур зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ, зардлыг Засаг даргын нөөц хөрөнгө (цаашид "нөөц хөрөнгө" гэх)-өөс санхүүжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнахад энэ журмыг мөрдөнө", 2015 оны 7 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан "Зардлын зориулалт, арга хэмжээний ангилал"-тай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

## **5.2. Зөвлөмж**

1. Шилэн дансны цахим системд 14,792.5 мянган төгрөгийн 1 орлогын гүйлгээ мэдээлээгүй, 8,905.8 мянган төгрөгийн 18 шийдвэр, таван саяас дээш орлогын 24,546.9 мянган төгрөгийн мэдээллийг тус тус хугацаа хоцроож байршуулсан нь мэдээллийн ил тод байдлыг хангахгүй байх, хуулийн хэрэгжилт хангалтгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8-т "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ", Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-т "цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт", 8.4.8-т "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байнга ил тод, нээлттэй байлгана" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны системд мэдээлээгүй 2 мэдээллийг нөхөн байршуулах, цаашид мэдээллийг хугацаанд нь байршуулж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого, үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд зардлын ангиллыг буруу илэрхийлсэн.	1	14,239.4			1	14,239.4	1	14,239.4				
Өглөг авлагыг санхүүгийн тайланд дутуу тайлагнасан.	1	552.8	1	552.9			1	552.8				
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг дутуу илэрхийлсэн.	1	1,103.6	1	1,103.6			1	1,103.6				
Бэлэн мөнгөний гүйлгээг кассын орлогоор дамжуулаагүй, өглөгийн дансанд бүртгэсэн	1	4,390.0			1	4,390.0	1	4,390.0				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>20,285.9</b>	<b>2</b>	<b>1,656.5</b>	<b>2</b>	<b>18,629.4</b>	<b>4</b>	<b>20,285.9</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Харицлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаа	Тоо	Дүн
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	4,998.8			1	4,998.8						
Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг дутуу тайлагнасан	1	662.1			1	662.1						
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>5,660.9</b>			<b>2</b>	<b>5,660.9</b>						

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
14,792.5 мянган төгрөгийн 1 орлогын гүйлгээ мэдээлээгүй, 8,905.8 мянган төгрөгийн 18 шийдвэр, таван саяас дээш орлогын 24,546.9 мянган төгрөгийн мэдээллийг тус тус хугацаа хоцроож байршуулсан	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>					<b>1</b>	<b>-</b>